


БАТЛАВ  
МОНГОЛ УЛСЫН САЙД,  
БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ  
ХОРООНЫ ДАРГА  Б.ТУЛГА

**III БҮЛЭГ. ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО, БООМТЫН СЭРГЭЛТИЙН  
БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУДЫГ ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭХ,  
СУРТАЛЧЛАХ СЭТГҮҮЛИЙН ЭХ БЭЛТГЭХ, ХЭВЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЖЛЫН ДААЛГАВАР**

**Үйлчилгээний нэр:** Шинэ сэргэлтийн бодлого, Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдсэн ажлуудыг олон нийтэд түгээх, сурталчлах сэтгүүл хэвлүүлэх.

**Гэрээний төрөл:** Хуулийн этгээд

**1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА**

Монгол Улсын Их Хурлаас баталсан Шинэ сэргэлтийн бодлого, Боомтын сэргэлтийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлыг олон нийтэд түгээх.

**2. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

- 2.1. Тусгай дугааруудад нийтлэгдэх мэдээ, мэдээлэл, сурвалжилга, ярилцлага, нийтлэлийг бэлтгэх, боловсруулах, хянаж, редакторлах, сэтгүүлийн зураг, дизайн, эх бэлтгэл, хэвлүүлэх ажлыг бүрэн гүйцэтгэх.
- 2.2. Сэтгүүлийн төлөвлөлт, сэтгүүлчийн ажил (нийтлэл бичих, мэдээллийг боловсруулах, томилолтоор сурвалжилга хийх), редактор, гэрэл зураг, дизайн (эх бэлтгэл, инфографик), англи хэлний орчуулга, сэтгүүлийн уншигч, захиалагчдад хүрэх.

**3. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Шаардлагатай тохиолдолд аливаа асуудлаар захиалагч байгууллагын удирдлагатай харьцана.

**4. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Үйлчилгээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 4.1. Гүйцэтгэгч тал нь “Боомтын сэргэлт Үндэсний форум 2024” арга хэмжээтэй холбоотой форумын онцлох хэсгүүдийг багтаасан сэтгүүлийн тусгай дугаарыг бэлтгэн гаргана;
- 4.2. Тус дугаарын төлөвлөлт, агуулгыг Захиалагч талд танилцуулж, оруулах нийтлэл, ярилцлага, мэдээ мэдээлэл дээр харилцан тохиролцох, хамтран ажиллах ба тус үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор Захиалагч талын хүсэлтээр сурвалжилга, ярилцлага, нийтлэл бэлтгэж гаргах ажлыг гүйцэтгэнэ;

- 4.3. Тусгай дугаарт нийтлэгдэх мэдээ, сурвалжилга, ярилцлага, нийтлэлүүд нь Монгол, Англи хэлээр гарах бөгөөд орчуулга нь мэргэжлийн өндөр түвшинд хийгдсэн байх;
- 4.4. Сэтгүүлийг хараат бус салбарын мэргэшсэн зөвлөхүүдээр хянуулж, баталгаажуулсан байх;
- 4.5. Гүйцэтгэгч Захиалагчаас заасан ажлуудыг нийтлэхээс өмнө Захиалагч талаар заавал баталгаажуулах ба тус үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, алдаа дутагдалгүй гүйцэтгэх;
- 4.6. Сэтгүүл нийтлэгдэх Захиалагчийн мэдээллийн эхийг сэтгүүлийн хэвлэлтэд орохоос ажлын 3 өдрийн өмнө Гүйцэтгэгч талд хүлээлгэн өгөх;
- 4.7. Гүйцэтгэгч тал сэтгүүлийн тусгай дугаарыг нийт 5500 ширхгийг Захиалагч талд хүлээлгэж өгөх.

Бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт

№	Бүтээгдэ хүүний нэр	Хэвлэх хэмжээ	Хэвлэх цаас	Хуудас ны тоо	Нийт хэвлэх тоо /ширхэг/	Тайлбар
1	Сэтгүүл	A4/210*297мм Өнгө: 4+4	Дотор цаас: 80гр, Хавтас цаас: 157гр	80-90	500	Монгол, Англи хэл дээр
2	Сэтгүүл	A4/210*297мм Өнгө: 4+4	Дотор цаас: 80гр, Хавтас цаас: 157гр	60-70	5000	Монгол хэл дээр

**5. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН:**

Үйлчилгээг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрсэн байна. Захиалагчийн захиалсан сэтгүүлийн тусгай дугаар нь захиалсан тоо ширхэг, цаасны төрөл, батлагдсан өнгө, загвар, бусад хэмжээ, норм стандарт, шаардлагын дагуу заасан хугацаанд хэвлэж захиалагчид нийлүүлсэн байна.

**6. АЖЛЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:**

Үйлчилгээг 1 сараас багагүй хугацаанд хийж гүйцэтгэнэ.

**7. ТӨСӨВТ ӨРТӨГ:**

Төсөвт өртөг 55.000.000 /тавин таван сая төгрөг/ төгрөг

**8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:** Гэрээний дагуу санхүүжилтийг ажлын үр дүнг үндэслэж гүйцэтгэлээр төлнө. Төлбөрийг монгол төгрөгөөр олгох бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид заасан татвар, даатгал, шимтгэл энэ үнийн дүнд багтсан болно.

**9. ХАРИУЦЛАГА**

9.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардагдсан аливаа материалыг гэрээнд зааснаас бусад өөр зорилгоор Захиалагчаас бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй;

- 9.2. Ажил гүйцэтгэхтэй холбоотой олж авсан, мэдсэн захиалагчтай холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, зураглал, тооцооллын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх.